



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2017 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

Агуулга

1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	2
1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	2
1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ	3
1.3.ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	4
1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ	5
1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	8
1.6.ДААТГАЛЫН НӨӨЦ САН	9
1.7.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА	10
1.8.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА	11
1.9.ДАВХАР ДААТГАЛ	12
2.ЕРДИЙН ДААТГАЛ	13
2.1.ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ	13
2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ	14
2.4.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	15
2.5.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА	15
3.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ	16
3.1.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ	16
3.2.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР	17
3.3.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ	17
3.4.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА	17
4.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ	18
5.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ	20
5.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ	20
5.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	22
6.ДААТГАЛЫН САЛБАРТ ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ	23
7. ДҮГНЭЛТ	25

1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 41, даатгалын хохирол үнэлэгч 30 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 252 салбар, 10 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 208 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 50 салбар, 2 төлөөлөгчийн газар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт-1

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2013	2014	2015	2016	2017.I
1	Ердийн даатгалын компани	16	16	15	15	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани			1	1	1
4	Даатгалын төлөөлөгч	3187	3260	3340	3091	3039
5	Даатгалын зуучлагч	20	30	37	40	41
6	Даатгалын хохирол үнэлэгч	14	20	27	31	30
7	Актуарч	15	15	15	15	16
8	Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани				42	42
9	Аудитор				126	126
	БҮГД	3253	3342	3436	3362	3310

Хүснэгт-2

Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо

№		2013	2014	2015	2016	2017.I
1	Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар	251	254	258	252	262
2	Даатгалын зуучлагч компанийн салбар	64	135	171	208	208
3	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар, төлөөлөгчийн газар	8	42	52	52	52
	БҮГД	323	431	481	513	522


2017 оны 1 дүгээр улиралд: Хорооны 2017 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “Эс Ти Ди” ХХК-д, 2017 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “Ивээлт очир” ХХК-д тус тус даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Хорооны 2017 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 13 дугаар тогтоолоор “Түвшин Ориент” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг, мөн өдрийн 15 дугаар тогтоолоор “Жи Эй Си Си” ХХК-ийн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон.

1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Тайлант хугацаанд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 224.8 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.9 тэрбум төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна.

Дүрслэл-1


Давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгө, түүний өсөлт



Даатгалын компаниудын нийт хөрөнгийн салбарын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 80.5 хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 16.1 хувь, урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 3.4 хувийг тус тус эзэлж байна. Ердийн, урт хугацааны болон давхар даатгалын компаниудын хөрөнгө, салбарын нийт хөрөнгөд эзлэх хувийг дараах дүрслэл болон хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

Дүрслэл-2

Салбарын хэмжээнд нийт хөрөнгөд эзлэх хувь



Даатгалын компаниудын нийт хөрөнгө


№	Даатгалын компани	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		Өсөлт/бууралт
		2016.03.31	2017.03.31	
1	Ард даатгал	8,811,926,561.94	9,033,154,282.36	2.5%
2	Бодь даатгал	17,149,632,796.01	24,669,102,734.91	43.8%
3	Ган зам даатгал	5,709,467,512.06	6,519,653,264.56	14.2%
4	Гэр даатгал	5,098,963,931.97	5,829,757,031.26	14.3%
5	Мандал даатгал	13,288,833,995.71	17,016,849,325.44	28.1%
6	Миг даатгал	10,354,167,698.62	11,357,073,753.38	9.7%
7	Монгол даатгал	28,418,376,484.73	32,008,851,829.49	12.6%
8	Монре даатгал	5,930,396,545.93	6,598,993,304.10	11.3%
9	Мөнх даатгал	4,269,470,314.00	4,324,258,076.00	1.3%
10	Нэйшнл лайф даатгал	8,645,970,121.17	7,696,899,016.04	19.8%
11	Номин даатгал	7,665,204,714.80	10,360,133,780.85	0.4%
12	Практикал даатгал	9,554,281,369.27	11,182,651,128.56	17.0%
13	Соёмбо даатгал	9,038,046,893.23	9,950,486,707.33	10.1%
14	Тэнгэр даатгал	13,354,552,875.18	18,136,661,907.87	35.8%
15	Улаанбаатар хотын даатгал	5,573,889,030.07	5,602,216,151.87	0.5%
16	Хаан даатгал	6,727,466,909.10	8,240,483,175.82	22.5%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	29,292,409,124.34	36,235,984,983.85	23.7%
	Нийт дүн	188,883,056,878.13	224,763,210,453.69	19.0%

1.3. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 8.7 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 19.4 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 7.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Сүүлийн 5 жилд даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн өсөх хандлагатай байгааг дараах дүрслэлээр харуулав.

Дүрслэл-3

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч
/тэрбум төгрөг/



Эзэмшигчийн өмчийн өсөлтийн шалтгаан нь Хорооны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн батлах” тухай 355 дугаар тогтоолын дагуу зарим нэр бүхий компаниуд дүрмийн сангийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт-4

Даатгалын компаниудын өр төлбөр, нөөц сан болон эзэмшигчийн өмчийн өсөлт

Үзүүлэлтүүд	2016.I		2017.I		Өөрчлөлт	
	Дүн төгрөгөөр	Эзлэх хувь	Дүн төгрөгөөр	Эзлэх хувь	Дүн төгрөгөөр	Эзлэх хувиар
Өр төлбөр	44,834,769,916.9	23.7%	64,237,735,991.9	28.6%	19,402,966,075.0	43.3%
Нөөц сан	46,288,338,474.3	24.5%	55,058,768,770.0	24.5%	8,770,430,295.7	18.9%
Эзэмшигчийн өмч	97,759,948,486.9	51.8%	105,466,705,691.7	46.9%	7,706,757,204.8	7.9%
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	188,883,056,878.1	100.0%	224,763,210,453.7	100.0%	35,880,153,575.5	70.1%

Хүснэгт-5

Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч, нөөц сан /төгрөгөөр/

№	Даатгалын компани	Нөөц сангийн дүн	Өр төлбөрийн дүн	Эздийн өмч	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч
1	Ард даатгал	1,490,457,332.09	4,746,526,041.38	4,286,628,240.98	9,033,154,282.36
2	Бодь даатгал	3,265,749,319.66	20,846,629,608.65	3,822,473,126.26	24,669,102,734.91
3	Ган зам даатгал	742,696,878.01	915,601,025.34	5,604,052,239.22	6,519,653,264.56
4	Гэр даатгал	824,168,346.66	1,246,049,969.82	4,583,707,061.44	5,829,757,031.26
5	Мандал даатгал	3,861,718,190.39	12,705,679,482.67	4,311,169,842.77	17,016,849,325.44
6	Миг даатгал	2,309,812,039.88	6,519,887,842.11	4,837,185,911.27	11,357,073,753.38
7	Монгол даатгал	10,689,020,792.11	22,213,991,213.66	9,794,860,615.83	32,008,851,829.49
8	Монре даатгал	566,269,430.67	2,071,300,580.89	4,527,692,723.21	6,598,993,304.10
9	Мөнх даатгал	324,752,859.00	417,981,124.00	3,906,276,952.00	4,324,258,076.00
10	Номин даатгал	4,286,539,007.61	6,121,220,110.53	4,238,913,670.32	10,360,133,780.85
11	Нэйшнл лайф даатгал	1,651,220,012.99	1,666,172,894.35	6,030,726,121.69	7,696,899,016.04
12	Практикал даатгал	2,926,867,067.33	6,013,676,717.42	5,168,974,411.14	11,182,651,128.56
13	Соёмбо даатгал	2,107,588,149.76	4,541,680,744.27	5,408,805,963.03	9,950,486,707.30
14	Тэнгэр даатгал	4,204,513,268.62	10,665,902,689.97	7,470,759,217.90	18,136,661,907.87
15	Улаанбаатар хотын даатгал	1,019,177,682.00	1,215,391,272.20	4,386,824,879.67	5,602,216,151.87
16	Хаан даатгал	1,375,951,372.92	3,242,444,538.72	4,998,038,637.10	8,240,483,175.82
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	13,412,267,020.31	14,146,368,905.95	22,089,616,077.90	36,235,984,983.85
	Нийт дүн	55,058,768,770.01	119,296,504,761.93	105,466,705,691.73	224,763,210,453.66


1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ

Даатгалын компаниуд 2017 оны 1 дүгээр улиралд 211,516 иргэн, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 37.5 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсний 97.6 хувь буюу 36.6 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.1 хувь буюу 0.4 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани, 1.3 хувь буюу 0.5 тэрбум төгрөгийг давхар даатгалын компани эзэлж байна. Даатгалын компаниудаас 5 тэрбум ба түүнээс дээш төгрөгийн даатгалын нийт

хураамжийн орлого төвлөрүүлсэн 2 даатгалын компани байгаа бөгөөд зах зээлийн нийт хураамжийн орлогын 57.3 хувь нь ногдож байна. Тайлант улирлын даатгалын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд сүүлийн 5 жилийн дундаж өсөлтийн хувиас 17.3 хувиар өсөлттэй байна.

Дүрслэл-4

Даатгалын хураамжийн нийт орлого, давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/



Дүрслэл-5

Даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын хураамж /төгрөгөөр/

№	Даатгалын компани	Даатгалын хураамжийн нийт орлого	Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого
1	Ард даатгал	1,308,446,250.00	27,393,761.00	283,759,231.00	997,293,258.00
2	Бодь даатгал	15,482,227,854.60	56,057,690.82	13,606,509,239.71	1,819,660,924.07
3	Ган зам даатгал	31,207,711.00	46,169.00	0.00	31,161,542.00
4	Гэр даатгал	218,570,007.00	14,579,656.30	0.00	203,990,350.70
5	Мандал даатгал	2,919,261,117.65	260,486,791.97	1,512,771,153.94	1,146,003,171.74
6	Миг даатгал	2,371,476,834.29	101,489,091.83	32,461,176.00	2,237,526,566.46
7	Монгол даатгал	6,004,172,326.83	107,111,898.95	2,517,374,542.09	3,379,685,885.79
8	Монре даатгал	890,249,654.39	42,699,149.47	22,218,768.22	825,331,736.70
9	Мөнх даатгал	133,430,030.00	0.00	0.00	133,430,030.00
10	Номин даатгал	931,016,950.93	45,056,515.14	148,978,819.56	736,981,616.23
11	Нэйшнл лайф даатгал	396,442,874.30	0.00	5,286,160.00	391,156,714.30
12	Практикал даатгал	1,483,636,299.25	46,856,009.61	13,745,938.34	1,423,034,351.30
13	Соёмбо даатгал	928,324,298.13	18,052,698.75	144,274,951.04	765,996,648.34
14	Тэнгэр даатгал	2,578,950,085.56	244,593,022.39	1,462,837,931.73	871,519,131.44
15	Улаанбаатар хотын даатгал	103,843,162.21	201,281.00	0.00	103,641,881.21
16	Хаан даатгал	1,225,953,751.91	16,531,152.22	58,078,437.79	1,151,344,161.90
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	504,350,897.30	0.00	214,044,436.31	290,306,460.99
	Нийт дүн	37,511,560,105.35	981,154,888.45	20,022,340,785.73	16,508,064,431.17

Тайлант хугацааны даатгалын хураамжийн нийт орлогын 75.3 хувь нь даатгалын 4 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдэж байгаагийн 36.3 хувийг хөрөнгийн даатгал, 16.5 хувийг ЖХАЖД, 9.6 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 6.9 хувийг гэнэтийн ослын даатгалын хураамж тус тус эзэлж байна.


Хүснэгт-7

Даатгалын хураамжийн нийт орлого / хэлбэрээр/

№	Даатгалын хэлбэр	Даатгалын хураамжийн нийт орлого		Өөрчлөлт/Бууралт
		2016.03.31	2017.03.31	
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	2,211,550,390.43	2,595,271,132.79	17.35%
2	Хөрөнгийн даатгал	13,237,618,283.13	13,610,579,406.60	2.82%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,601,979,207.55	3,598,961,414.83	38.32%
4	Ачааны даатгал	233,513,189.82	237,711,654.74	1.80%
5	Барилга угсралтын даатгал	101,376,535.17	69,258,770.71	-31.68%
6	Мал амьтдын даатгал	19,865,022.00	47,882,980.00	141.04%
7	Агаарын хөлгийн даатгал	361,780,725.94	1,010,794,566.05	179.39%
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	57,626,553.30	73,395,353.76	27.36%
9	Хариуцлагын даатгал	1,578,442,264.71	3,290,954,824.95	108.49%
10	Санхүүгийн даатгал	669,410,700.56	546,287,189.53	-18.39%
11	Зээлийн даатгал	194,350,467.10	291,638,347.28	50.06%
12	Итгэлцлийн даатгал	15,871,851.44	218,896,693.48	1279.15%
13	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	412,714,651.86	4,842,114,600.05	1073.24%
14	Жолоочийн хариуцлагын даатгал	5,234,164,056.16	6,177,019,398.98	18.01%
15	Хугацаат амьдралын даатгал	30,761,900.13	63,583,752.06	106.70%
16	Хуримтлалын даатгал	28,982,601.00	37,119,725.00	28.08%
17	Тэтгэврийн даатгал	15,785,622.78	27,976,219.00	77.23%
18	Эрүүл мэндийн даатгал	227,488,318.66	267,763,178.24	17.70%
19	Мал амьтдын давхар даатгал	-	504,350,897.30	0.00%
Нийт дүн		27,233,282,341.75	37,511,560,105.4	37.74%

Дүрслэл-6

Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт



1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Даатгалын тохиолдлын улмаас 2017 оны 1 дүгээр улиралд нийт 15,751 даатгуулагчдад 8.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Тайлант хугацаанд “Монгол даатгал” ХХК 1.72 тэрбум төгрөгийн, “Миг даатгал” ХХК 1.29 тэрбум төгрөгийн, “Мандал даатгал” ХХК 1.17 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь хамгийн өндөр бөгөөд нийт нөхөн төлбөрийн 47.4 хувийг эзэлж байна. Нийт салбарын хэмжээнд авч үзвэл нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт-8

№	Даатгалын компани	Нийт нөхөн төлбөрийн зардал /төгрөгөөр/		Өсөлт/ бууралт (хувиар)
		2016.03.31	2017.03.31	
1	Ард даатгал	666,242,457.42	584,042,398.00	-12.3%
2	Бодь даатгал	736,042,632.33	835,149,610.00	13.5%
3	Ган зам даатгал	7,065,527.00	21,978,873.00	211.1%
4	Гэр даатгал	22,027,133.00	64,399,653.00	192.4%
5	Мандал даатгал	1,105,206,540.98	1,167,804,190.81	5.7%
6	Миг даатгал	1,201,190,032.70	1,293,406,726.08	7.7%
7	Монгол даатгал	1,680,066,556.08	1,716,213,285.61	2.2%
8	Монре даатгал	552,895,058.00	539,918,271.92	-2.3%
9	Мөнх даатгал	4,041,669.00	11,211,100.00	177.4%
10	Номин даатгал	312,228,753.00	357,243,352.04	14.4%
11	Нэйшнл лайф даатгал	212,985,583.40	176,821,944.13	-17.0%
12	Практикал даатгал	759,237,010.00	855,358,289.19	12.7%
13	Соёмбо даатгал	512,382,298.92	408,371,952.74	-20.3%
14	Тэнгэр даатгал	596,374,022.13	470,045,822.00	-21.2%
15	Улаанбаатар хотын даатгал	23,134,851.00	19,254,990.00	-16.8%
16	Хаан даатгал	183,966,581.00	291,640,404.00	58.5%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	-	-	-
	Нийт дүн	8,575,086,705.96	8,812,860,862.52	2.8%

Даатгалын компаниудын нөхөн төлбөрийн хэмжээг сүүлийн 5 жилийн байдлаар доорх хүснэгтэд харуулав. 2013 оны 1 дүгээр улирлаас хойш давхар даатгагчаас олгох нөхөн төлбөрийн хэмжээ жил бүр өсөх хандлагатай байна.

Дүрслэл -7

Даатгалын нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/



Даатгалын компаниудын даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар 8,727 даатгуулагчид нийт 4.4 тэрбум төгрөгийн, авто тээврийн хэрэгслийн даатгалаар 3,225 даатгуулагчид 2.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр олгосон даатгалын хэлбэрүүд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн даатгалын нөхөн төлбөр хамгийн их өсөлттэй буюу 29.4 дахин өссөн бол хариуцлагын даатгал болон зээлийн даатгалын хэлбэрээр нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 2.9 болон 3.6 дахин тус тус өссөн байна.

Хүснэгт-9


№	Даатгалын хэлбэр	2016.03.31		2017.03.31	
		Нөхөн төлбөр /төгрөгөөр/	Нөхөн төлбөр авсан гэрээний тоо	Нөхөн төлбөр /төгрөгөөр/	Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	672,587,998.8	2,065.0	998,586,365.8	2,129.0
2	Хөрөнгийн даатгал	621,269,291.2	536.0	381,089,437.3	602.0
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,051,960,164.7	3,371.0	2,123,090,722.5	3,225.0
4	Ачааны даатгал	16,295,249.8	5.0	4,976,670.0	6.0
5	Барилга угсралтын даатгал	5,706,880.0	-	-	-
6	Мал амьтдын даатгал	25,689,600.0	1.0	-	-
7	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	7,934,900.0	234.0	11,359,640.0	34.0
8	Хариуцлагын даатгал	133,430,221.0	94.0	147,286,787.2	275.0
9	Санхүүгийн даатгал	344,637,654.7	160.0	416,232,361.2	107.0
10	Зээлийн даатгал	5,298,343.3	9.0	156,239,265.4	33.0
11	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	1,035,000.0	3.0	1,811,660.3	1.0
12	Жолоочийн хариуцлагын даатгал	4,316,612,095.3	8,457.0	4,395,366,008.8	8,727.0
13	Хугацаат амьдралын даатгал	21,279,579.0	23.0	12,770,100.0	23.0
14	Хуримтлалын даатгал	26,106,874.0	13.0	14,518,986.0	4.0
15	Тэтгэврийн даатгал	2,876,141.0	5.0	4,486,917.0	-
16	Эрүүл мэндийн даатгал	162,722,989.4	584.0	145,045,941.1	585.0
	Нийт дүн	8,415,442,982.2	15,560.0	8,812,860,862.5	15,751.0

: Тайлант хугацаанд нөхөн төлбөр гараагүй даатгалын хэлбэрүүдийг дээрх хүснэгтэд оруулаагүй болно.

1.6.ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 2017 оны 1 дүгээр улиралд 55.1 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 54.4 хувиар өссөн байна. Энэхүү тайлант хугацаанд нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад ердийн даатгалын “Хаан даатгал” ХХК 83.2 хувиар, “Мандал даатгал” ХХК 67.0 хувиар, “Бодь даатгал” 34.8 хувиар, “Номин даатгал” ХХК 32.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын салбарын хэмжээнд “Монгол даатгал” ХХК, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-иуд нийт нөөц сангийн 40.0 хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацааны даатгалын нөөц сангийн өсөлтийг дараах дүрслэлээр харуулав.

Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ болон өсөлтийн хувь




1.7.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт хохирлын харьцаа 23.1 хувьтай байна. Үүнд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлогоос тооцсон орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 42.7 хувьтай байна. Даатгалын компаниудын хохирлын харьцааны хувьд ердийн даатгалын компаниудаас “Монре даатгал” ХХК-ийн хохирлын харьцаа 73.7 хувь байгаа нь хамгийн өндөр, “Бодь даатгал” ХХК хамгийн бага буюу 5.4 хувийн хохирлын харьцаатай бол “Нэйшнл лайф даатгал” ХХК-ын хохирлын харьцаа 80.5 хувь тус тус байна.

Дүрслэл-9

Даатгалын хохирлын харьцаа



Даатгалын компаниудын хохирлын харьцаа

№	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж	Даатгагчаас олгосон нөхөн төлбөр	Хохирлын харьцаа /цэвэр/
1	Ард даатгал	1,388,567,957.0	530,948,348.0	38.2%
2	Бодь даатгал	1,797,965,270.1	740,887,107.7	41.2%
3	Ган зам даатгал	135,152,732.5	21,978,873.0	16.3%
4	Гэр даатгал	115,982,523.6	64,399,653.0	55.5%
5	Мандал даатгал	1,289,975,716.7	621,786,255.6	48.2%
6	Миг даатгал	2,134,547,504.5	1,253,340,445.9	58.7%
7	Монгол даатгал	3,788,775,244.0	1,507,497,478.6	39.8%
8	Монре даатгал	710,133,844.3	539,918,271.9	76.0%
9	Мөнх даатгал	186,890,114.0	11,211,100.0	6.0%
10	Номин даатгал	868,508,382.6	355,127,409.2	40.9%
11	Нэйшнл лайф даатгал	214,334,770.2	176,821,944.1	82.5%
12	Практикал даатгал	1,428,444,407.0	797,945,909.2	55.9%
13	Соёмбо даатгал	1,042,818,607.2	337,507,002.0	32.4%
14	Тэнгэр даатгал	1,602,272,206.5	469,347,593.7	29.3%
15	Улаанбаатар хотын даатгал	151,235,646.2	19,254,990.0	12.7%
16	Хаан даатгал	958,781,812.6	291,416,404.0	30.4%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	290,306,461.0	-	0.0%
	Нийт дүн	18,104,693,200.0	7,739,388,785.8	42.7%

Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийг оруулж тооцсон хохирлын харьцаа

№	Даатгалын компани	Нийт орлогод тооцсон хураамж+Давхар даатгалын хураамж	Нийт нөхөн төлбөр	Хохирлын харьцаа /нийт/
1	Ард даатгал	1,672,327,188.0	584,042,398.0	34.9%
2	Бодь даатгал	15,404,474,509.8	835,149,610.0	5.4%
3	Ган зам даатгал	135,152,732.5	21,978,873.0	16.3%
4	Гэр даатгал	115,982,523.6	64,399,653.0	55.5%
5	Мандал даатгал	2,802,746,870.7	1,167,804,190.8	41.7%
6	Миг даатгал	2,167,008,680.5	1,293,406,726.1	59.7%
7	Монгол даатгал	6,306,149,786.1	1,716,213,285.6	27.2%
8	Монре даатгал	732,352,612.5	539,918,271.9	73.7%
9	Мөнх даатгал	186,890,114.0	11,211,100.0	6.0%
10	Номин даатгал	1,017,487,202.2	357,243,352.0	35.1%
11	Нэйшнл лайф даатгал	219,620,930.2	176,821,944.1	80.5%
12	Практикал даатгал	1,442,190,345.3	855,358,289.2	59.3%
13	Соёмбо даатгал	1,187,093,558.3	408,371,952.7	34.4%
14	Тэнгэр даатгал	3,065,110,138.2	470,045,822.0	15.3%
15	Улаанбаатар хотын даатгал	151,235,646.2	19,254,990.0	12.7%
16	Хаан даатгал	1,016,860,250.4	291,640,404.0	28.7%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	504,350,897.3	-	-
	Нийт дүн	38,127,033,985.7	8,812,860,862.5	23.1%

1.8.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын компаниудын цэвэр ашиг 2017 оны 1 дүгээр улиралд 877.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3,007.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны мөн үеэс 8 даатгалын компанийн цэвэр ашиг буурсан нь нийт салбарын хувьд өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурахад нөлөөлж


байна. Салбарын хэмжээнд цэвэр ашгийн бууралтад “Бодь даатгал” ХХК, “Мандал даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК-иуд тайлант хугацаанд алдагдалтай ажилласан нь гол нөлөөлөгч хүчин зүйл болсон байна. Мөн тайлант хугацаанд “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн хувьд 43.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж хуримтлагдсан алдагдал нь 348.1 сая төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт-12

№	Даатгалын компани	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		
		2016.03.31	2017.03.31	өсөлт /бууралт/ хувиар
1	Ард даатгал	-225,315,522.5	44,121,443.4	-1.2
2	Бодь даатгал	964,298,389.1	-1,314,968,548.0	-2.4
3	Ган зам даатгал	253,774,475.3	243,152,550.5	0.0
4	Гэр даатгал	166,906,156.0	96,557,524.2	-0.4
5	Мандал даатгал	-314,685,977.3	-587,196,535.6	0.9
6	Миг даатгал	1,580,574,217.6	-277,870,792.1	-1.2
7	Монгол даатгал	46,983,029.3	216,964,056.1	3.6
8	Монре даатгал	17,891,715.0	-193,634,542.7	-11.8
9	Мөнх даатгал	3,184,748.0	73,943,070.0	22.2
10	Номин даатгал	42,738,525.8	6,137,118.6	-0.9
11	Нэйшнл лайф даатгал	16,733,204.0	43,519,839.9	1.6
12	Практикал даатгал	7,030,974.1	145,012,565.0	19.6
13	Соёмбо даатгал	200,470,749.8	414,305,496.7	1.1
14	Тэнгэр даатгал	537,168,627.1	599,828,285.3	0.1
15	Улаанбаатар хотын даатгал	54,124,647.8	3,844,400.3	-0.9
16	Хаан даатгал	139,230,787.4	343,443,789.2	1.5
17	ХАА-н давхар даатгал	393,648,753.3	1,020,174,205.3	1.6
	НИЙТ	3,884,757,499.5	877,333,926.2	-0.8

Дүрслэл-10

Тайлант үеийн цэвэр ашиг/тэрбум төгрөг/




1.9. ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь давхар даатгалын үйл ажиллагаа явуулж 0.5 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төвлөрүүлж, 0.2 тэрбум төгрөгийг гадаадын давхар даатгагчид төлсөн байна. Харин ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 19.8 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн дүнгээс 6.9 тэрбум төгрөгөөр буюу 52.8

хувиар өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогоос 53.4 хувийг нь давхар даатгалд төлсөн байгаа нь өндөр үзүүлэлт юм. “Бодь даатгал” ХХК-ийн хувьд давхар даатгалд төлсөн хураамж нь нийт хураамжийнхаа 87.9 хувийг, “Мандал даатгал” ХХК-ийн хувьд 51.8 хувийг, “Тэнгэр даатгал” ХХК-ийн хувьд 56.7 хувь байгаа нь нийт салбарын үзүүлэлтэд ихээр нөлөөлсөн. Сүүлийн 5 жилийн байдлаар давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр, хураамжийн өсөлтийг дараах дүрслэлээр харуулав. Тайлант хугацаанд давхар даатгагчаас 0.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт давхар даатгалын хураамжийн 4.3 хувийг эзэлж байна.

Дүрслэл-11




2.ЕРДИЙН ДААТГАЛ

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 15 ердийн даатгалын компани, тэдгээрийн 262 салбар, төлөөлөгчийн газар Улаанбаатар хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

2.1.ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ

Ердийн даатгалын 15 компанийн нийт хөрөнгийн хэмжээ тайлант хугацаанд 180.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 28.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн байдлаар ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ тогтмол өсөлттэй байгааг дүрслэл 12-д харуулав.

Дүрслэл-12




2.2.ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2017 оны 1 дүгээр улирлын байдлаарх ердийн даатгалын компаниудын нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмч, нөөц сангийн харьцааг дараах дүрслэлээр харуулав. Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн талаар 1.3 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

Дүрслэл-13

Ердийн даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч ба нөөц сангийн харьцаа



2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 14 даатгалын хэлбэрээр 36.6 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, үүнээс давхар даатгалын хураамжид 19.8 тэрбум төгрөг төлж, 0.98 тэрбум төгрөгийн хураамжийг даатгуулагч нарт буцаан олгосноор 15.8 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлоготойгоор тайлагнасан байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлогын талаар 1.4 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Ердийн даатгалын нийт хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр ангилж, дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт-13

№	Даатгалын хэлбэр	Ердийн даатгалын нийт хураамжийн орлого	Нийт даатгалын хураамжид эзлэх хувь
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	2,595,271,132.79	7.1%
2	Хөрөнгийн даатгал	13,610,579,406.60	37.2%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	3,598,961,414.83	9.8%
4	Ачааны даатгал	237,711,654.74	0.6%
5	Барилга угсралтын даатгал	69,258,770.71	0.2%
6	Мал амьтдын даатгал	47,882,980.00	7.1%
7	Агаарын хөлгийн даатгал	1,010,794,566.05	2.8%
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	73,395,353.76	0.2%
9	Хариуцлагын даатгал	3,290,954,824.95	9.0%
10	Санхүүгийн даатгал	546,287,189.53	1.5%
11	Зээлийн даатгал	291,638,347.28	0.8%
12	Итгэлцлийн даатгал	218,896,693.48	0.6%
13	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	4,842,114,600.05	13.2%
14	Жолоочийн хариуцлагын даатгал	6,177,019,398.98	16.9%
	Нийт дүн	36,610,766,333.75	100.0%

2.4.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР


Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 8.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчид олгосноос 0.9 тэрбум төгрөгийг давхар даатгагч, 0.2 тэрбум төгрөгийг буруутай этгээд, 7.7 тэрбум төгрөгийг даатгагч нар тус тус төлсөн байна. Ердийн даатгалын компаниудын олгосон нөхөн төлбөр нь салбарын нийт нөхөн төлбөрийн 98.0 хувийг эзэлж байна. Даатгалын нөхөн төлбөрийн талаар 1.5 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

2.5.ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН АШИГТ АЖИЛЛАГАА

Ердийн даатгалын компаниудын 2017 оны 1 дүгээр улирлын ашигт ажиллагааг 1.8 дахь хэсэгт дэлгэрэнгүй харуулсан бөгөөд тайлант хугацааны ашигт ажиллагааг өмнөх оны мөн үетэй харьцуулсан дүрслэлийг дараах байдлаар харуулав.

Дүрслэл-14

Ердийн даатгалын компаниудын ашигт ажиллагаа



2.6.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нөөц сан 39,995.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6,916.4 сая төгрөгөөр буюу 20.9 хувиар өссөн байна.

/төгрөгөөр/ Хүснэгт-14

Ердийн даатгалын төрөл	Даатгалын нөөц сан	2016.03.31	2017.03.31
1. Сайн дурын даатгал	Орлогд тооцоогүй хураамжийн нөөц сан	-	-
	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	4,840,432,486.58	5,486,135,016.00
	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	1,731,677,852.15	3,502,086,897.00
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	3,900,590,545.68	4,732,846,401.00
2. Албан журмын даатгал	Орлогд тооцоогүй хураамжийн нөөц сан	-	-
	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	2,172,621,452.35	2,820,077,325.58
	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	665,138,059.34	990,880,723.79
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	1,223,610,178.08	2,805,945,670.24
	Тусгай нөөц сан	18,544,825,334.06	19,657,309,703.03
ДҮН		33,078,895,908	39,995,281,737

Ердийн даатгагчид өөрийн хүлээж чадах эрсдэлээс давсан хэсгийг гадаадын давхар даатгагчид даатгуулахад тайлант хугацаанд 19.8 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 51.0 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд гадаадын давхар даатгагч нараас ердийн даатгалын 6 хэлбэрийн нөхөн төлбөрт 0.9 тэрбум төгрөг олгосон байна. Давхар даатгалын талаар 1.9 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

/төгрөгөөр/ Хүснэгт-15

№	Даатгалын компани	Давхар даатгалын хураамжийн зардал		Өөрчлөлт
		2016.03.31	2017.03.31	
1	Ард даатгал	138,957,979.14	283,759,231.25	144,801,252.11
2	Бодь даатгал	9,257,255,995.62	13,606,509,239.71	4,349,253,244.09
3	Ган зам даатгал	0.00	0.00	0.00
4	Гэр даатгал	0.00	0.00	0.00
5	Мандал даатгал	1,227,851,014.17	1,512,771,153.94	284,920,139.77
6	Миг даатгал	0.00	32,461,176.00	32,461,176.00
7	Монгол даатгал	1,862,027,092.06	2,517,374,542.09	655,347,450.03
8	Монре даатгал	0.00	22,218,768.22	22,218,768.22
9	Мөнх даатгал	0.00	0.00	0.00
10	Номин даатгал	123,963,208.00	148,978,819.56	25,015,611.56
12	Практикал даатгал	138,976,425.04	13,745,938.34	(125,230,486.70)
13	Соёмбо даатгал	57,415,637.60	144,274,951.04	86,859,313.44
14	Тэнгэр даатгал	277,197,390.34	1,462,837,931.73	1,185,640,541.39
15	Улаанбаатар хотын даатгал	0.00	0.00	0.00
16	Хаан даатгал	28,349,996.57	58,078,437.79	29,728,441.22
	Нийт дүн	13,111,994,738.54	19,803,010,189.7	6,691,015,451.13


3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос хойш урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийн хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өссөн бөгөөд тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ 7.7 тэрбум төгрөгт болж өмнөх оны мөн үеийнхээс 0.3 хувиар өссөн байна.

Дүрслэл-15

Урт хугацааны даатгагчийн нийт хөрөнгө/ тэрбум төгрөг/




3.2. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн нийт орлого тайлант хугацаанд 396.4 сая төгрөгт болж өмнөх оны мөн үеэс 93.4 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацааны нийт нөхөн төлбөр 176.8 сая төгрөг бөгөөд урт хугацааны даатгагчийн хураамжийн нийт орлого, нийт нөхөн төлбөрийн харьцаа 44.6 хувьтай байна. Тайлант улирлын урт хугацааны даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг сүүлийн жилүүдтэй харьцуулав.

Дүрсэл-16

Урт хугацааны даатгагчийн нийт хураамжийн орлого, нөхөн төлбөр




3.3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

Давхар даатгалын хураамжид тайлант хугацаанд 5.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Урт хугацааны даатгалын сүүлийн 5 жилийн давхар даатгалын хураамжийг дүрслэлээр харуулав.

Дүрслэл-17


Урт хугацааны даатгалын компанийн давхар даатгалын хураамж /сая.төг/



3.4. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА

Сүүлийн жилүүдэд урт хугацааны даатгалын хураамжийн орлогын өсөлттэй холбоотой даатгалын нөөц сангийн хэмжээ нь тогтмол өсөж байна. Тайлант хугацаанд урт хугацааны даатгагчийн нөөц сан 1651.2 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өссөн байна.


Урт хугацааны даатгагчын нөөц сан /сая.төг/



“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж эхэлснээс хойш алдагдалтай ажиллаж байсан бол 2014 оноос эхлэн ашигтай ажиллаж, 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 43.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, хуримтлагдсан алдагдал нь 348.1 сая төгрөг болж буурсан байна. Мөн цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.7 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь урт хугацааны даатгалын хураамжийн өсөлтөөс шалтгаалжээ. Урт хугацааны даатгагчийн ашигт ажиллагааг сүүлийн 5 жилийн байдлаар дараах дүрслэлээр харуулав.

Дүрслэл-19

Урт хугацааны даатгагчийн цэвэр ашиг, алдагдал / сая төгрөг/



4.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ


2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “жолоочийн хариуцлагын даатгал” гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж 6.2 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.94 тэрбум төгрөгөөр өссөн байна.

№	Даатгалын компани	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого /төгрөгөөр/		
		2016.03.31	2017.03.31	Өөрчлөлт
1	Ард даатгал	389,308,253.94	354,188,785.00	-35,119,468.94
2	Бодь даатгал	560,200,994.10	696,143,576.05	135,942,581.95
3	Ган зам даатгал	4,921,676.00	4,850,121.00	-71,555.00
4	Гэр даатгал	34,672,478.00	189,586,302.00	154,913,824.00
5	Мандал даатгал	629,156,838.00	501,523,767.00	-127,633,071.00
6	Миг даатгал	704,173,845.65	1,001,649,020.25	297,475,174.60
7	Монгол даатгал	999,589,025.88	960,872,926.53	-38,716,099.35
8	Монре даатгал	412,118,151.08	543,917,307.73	131,799,156.65
9	Мөнх даатгал	82,474,281.00	85,782,965.00	3,308,684.00
10	Номин даатгал	333,643,456.50	424,922,475.00	91,279,018.50
11	Практикал даатгал	376,477,963.36	471,162,851.81	94,684,888.45
12	Соёмбо даатгал	219,266,136.45	348,604,067.61	129,337,931.16
13	Тэнгэр даатгал	333,245,181.20	410,155,386.00	76,910,204.80
14	Улаанбаатар хотын даатгал	849,238.00	577,863.00	-271,375.00
15	Хаан даатгал	154,066,537.00	183,081,985.00	29,015,448.00
	Нийт	5,234,164,056.16	6,177,019,398.98	942,855,342.82

Тайлант хугацаанд даатгалын компаниуд жолоочийн хариуцлагын даатгалын 6,296 тохиолдолд нийт 4.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Албан журмын болон сайн дурын даатгалын нийт хураамжийн орлого, нийт нөхөн төлбөр, хохирол нөхөлтийн харьцааг доорх дүрслэлээр харьцуулж харуулав.


Дүрслэл-20

Даатгалын төрлөөр нийт хураамжийн орлого, нөхөн төлбөр /2017.1/



Сүүлийн 3 жилийн статистикаас харахад жолоочийн хариуцлагын даатгалын 1 гэрээ тутамд ногдож буй даатгалын тохиолдол болох магадлал нь дараах байдалтай байна.

ЖХАЖД-ын тохиолдол



5.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

5.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

2017 оны 1 дүгээр улиралд даатгалын зуучлалын 41 компаниас 5 компанийн тайлан Фина санхүүгийн системд ирүүлээгүй бөгөөд нэгтгэлд орсон 34 компаниас 2 компани даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлээгүй байна. Тайлант хугацаанд 24 даатгалын зуучлагч компани, 8 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж нийт 5.0 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий ердийн даатгалын 14, урт хугацааны даатгалын 2 хэлбэр зуучилж, 10.4 тэрбум төгрөгийн зуучилсан даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн нь салбарын нийт хураамжийн орлогын 15.6 хувийг бүрдүүлж байна.

/төгрөгөөр/ Хүснэгт-17

№	Даатгалын зуучлалын компани	2016.03.31		2017.03.31	
		Зуучилсан даатгалын хураамжийн орлого	Даатгалын зуучлалын орлого	Зуучилсан даатгалын хураамжийн орлого	Даатгалын зуучлалын орлого
1	АМЕ	306,852,171.0	12,165,424.0	.00	.00
2	Ай Ай Би	0.0	0.0	460,474,582.45	25,125,084.00
3	Ар Эм Ай Би	0.0	0.0		#N/A
4	Ариг банк	7,554,827.1	1,561,097.2	12,338,910.62	2,576,793.22
5	Арм интернэшнл	0.0	0.0	#N/A	#N/A
6	Асимон брокерс	982,811,128.7	45,262,807.7	3,209,346,238.73	109,074,143.52
7	Ачит ундарга	101,377,279.7	24,798,548.2	29,902,257.29	4,511,908.01
8	Бест солюшн			195,413,636.07	13,609,877.13
9	Ваясню Солюшн	21,750,531.0	6,511,209.0	351,488,412.00	51,468,097.00
10	Голомт банк	0.0	0.0	666,025,187.00	95,885,612.00
11	Гэрэлт буян ундрах	163,039,709.0	48,425,950.0	2,478,411.00	406,707.00
12	Дэвжих дэлгэрэх холдинг	17,589,030.0	3,043,394.0	21,781,824.24	4,841,678.97
13	Капитал банк	0.0	0.0	25,808,721.00	6,556,144.00
14	Ковер хилл			59,920,292.00	11,748,846.93
15	Лояалти солюшн	164,654,205.0	51,323,700.0	#N/A	#N/A
16	Мастер шийдэл	0.0	0.0	37,335,021.00	7,543,394.70
17	Монгол бичээч зууч	4,237,373.0	1,271,211.9	#N/A	#N/A
18	Монголиан интернэшнл брокерс	0.0	0.0	9,587,052.00	2,370,660.40


19	Монголиан иншуранс Брокерейж	0.0	0.0	109,286,291.00	21,864,815.00
20	Нэйшнл эженси	46,148,763.0	13,844,629.0	2,257,065.00	446,512.50
21	Ренессанс групп	14,265,103.1	3,395,599.0	157,469,648.98	43,392,427.04
22	Си эн эн икс	87,599,564.2	16,267,201.9	406,673,414.00	112,866,779.98
23	Соёомбо Ай Би	583,425.0	175,027.5	#N/A	#N/A
24	Сүрэг хараацай	318,986,578.0	76,567,412.0	825,976,782.00	170,208,412.53
25	Тод капитал	0.0	0.0	160,911,891.00	28,497,811.71
26	Төрийн банк	172,548,845.9	39,257,739.3	382,190,560.49	78,068,958.86
27	Тус брокерс	0.0	0.0	.00	.00
28	Түвшин ориент	0.0	0.0	#N/A	#N/A
29	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	10,494,917.0	1,786,652.0	673,949,372.24	144,351,985.11
30	Хаан банк	759,885,273.0	154,211,949.0	750,143,055.93	148,964,517.81
31	ХасБанк	231,577,724.5	46,165,391.4	422,100,125.66	63,567,093.32
32	Худалдаа хөгжлийн банк	594,538,380.7	80,006,470.8	907,384,819.33	142,635,121.71
33	Хүннү сизл	3,083,950.9	925,293.3	106,920.00	21,384.00
34	Цагаан гэрэлт	0.0	0.0	22,134,461.00	5,015,096.00
35	Эй Эс Ай Би	0.0	0.0	.00	.00
36	Эл Би брокерэж	0.0	0.0	329,677,806.00	73,175,346.07
37	Эм жи ай би	7,000,000.0	1,400,000.0	.00	.00
38	Эрсдэлийн шийдэл	1,168,364,308.0	349,685,561.9	161,189,601.00	30,176,750.40
39	Эс ай би эс	0.0	0.0	19,038,623.00	3,141,366.00
	Нийт	13,569,563,826.3	1,002,616,800.8	10,412,390,982.03	1,402,113,324.92

Тэмдэглэл:(0.0)-үйл ажиллагаа эрхлээгүй, (#N/A)-Фина системд тайлан ирүүлээгүй


2017 оны 1 дүгээр улиралд даатгалын зуучлагч компани 719.5 сая төгрөгийн, даатгалын зуучлагч банк 682.6 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого тайлагнасан бөгөөд нийт даатгалын зуучлалын орлого 1402.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар өссөн байна.

Дүрслэл-22

Даатгалын зуучлалын орлого /тэрбум төгрөг/



Даатгалын зуучлалын орлогын өсөлт



5.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Даатгалын хохирол үнэлэгч 30 компаниас 2017 оны 1 дүгээр улиралд 21 компани үйл ажиллагаа явуулж тайлант хугацаанд нийт 3.6 тэрбум төгрөгийн даатгалын хохирлын үнэлгээ бүхий 6,202 удаагийн даатгалын хохирлын үнэлгээ хийж, 148.6 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Нийт дүнгээрээ даатгалын хохирол үнэлгээний орлого нь өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар буурсан байна.

/төгрөгөөр/ Хүснэгт-18


№	Хохирол үнэлэгч компани	2016.03.31			2017.03.31		
		Даатгалын хохирлын нийт үнэлгээ	Даатгалын хохирлыг үнэлсэн тоо	Даатгалын хохирол үнэлгээний орлого	Даатгалын хохирлын нийт үнэлгээ	Даатгалын хохирлыг үнэлсэн тоо	Даатгалын хохирол үнэлгээний орлого
1	Аа аперейзал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	Арвижих эстимэйт	134,705,981.0	204.0	5,045,750.0	23,405,210.0	35.0	1,018,000.0
3	Арга билэг эстимэйт	52,195,591.0	147.0	3,881,000.0	0.0	0.0	0.0
4	Ашид билгүүн	268,350,489.0	2,074.0	83,767,290.0	722,121,110.0	1,695.0	47,041,102.0
5	Банхас	#N/A	#N/A	#N/A	118,007,759.0	237.0	3,976,000.0
6	Бэст эстимэйт	123,065,000.0	41.0	1,545,206.4	49,634,000.0	19.0	1,425,909.1
7	Вендо	1,205,932,156.4	1,323.0	31,939,091.9	1,131,121,685.0	712.0	19,464,000.0
8	Виннэрвэй	#N/A	#N/A	#N/A	11,158,000.0	4.0	257,000.0
9	Гэрэгэ эстимэйт	263,887,386.0	494.0	11,577,500.0	311,353,784.0	715.0	17,525,224.6
10	Далайван аудит	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
11	Жи эй си си	34,659,470.0	61.0	1,765,000.0	#N/A	#N/A	#N/A
12	Итгэлт эстимэйт	106,466,416.0	122.0	3,401,817.0	88,900,165.0	116.0	3,259,091.2
13	Капитал эстимэйт	#N/A	#N/A	#N/A	#N/A	#N/A	#N/A
14	Кости эстимэйт	100,640,250.0	273.0	5,346,500.0	193,703,200.0	484.0	10,259,091.0
15	Лэндс	48,039,062.0	123.0	2,111,818.2	#N/A	#N/A	#N/A
16	Мастер	100,561,860.0	185.0	5,245,455.0	207,929,380.0	408.0	10,857,272.7

	Үнэлгээ						
17	Мега марз	0.0	0.0	0.0	10,810,000.0	34.0	752,727.3
18	Мөнх эстимэйт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
19	Нарангэрэгэ	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
20	Сэлэнгэ эстимэйт	62,437,010.0	105.0	2,948,000.0	44,095,505.0	68.0	1,819,060.0
21	Тэгшсонголт эстимэйт	20,305,870.0	23.0	658,181.8	12,578,200.0	16.0	806,000.0
22	Тэнцвэр эстимэйт	0.0	0.0	0.0	33,787,885.0	30.0	937,272.8
23	Ухаашүрт консалтинг	126,257,672.0	709.0	5,272,727.0	25,560,000.0	66.0	1,807,000.0
24	Үнэлгээ консалтинг	0.0	0.0	0.0	290,250,590.0	869.0	8,577,273.0
25	Файн эстимэйт	0.0	0.0	0.0	68,439,689.0	155.0	2,436,750.0
26	Фэйр валуэшн	73,048,820.0	167.0	4,191,500.0	650,000.0	2.0	50,000.0
27	Хас үнэлгээ	#N/A	#N/A	#N/A	111,829,250.0	257.0	6,499,000.0
28	Хос стандарт	37,420,000.0	93.0	4,785,000.0	9,155,000.0	2.0	198,000.0
29	Хөрөнгө үнэлгээний төв	1,360,000.0	9.0	290,000.0	#N/A	#N/A	#N/A
30	Хөрөнгө эстимэйт	97,200,250.0	153.0	4,814,000.0	180,487,300.0	278.0	9,639,000.0
31	Юу Энд Эн	#N/A	#N/A	#N/A	#N/A	#N/A	#N/A
	Нийт дүн	2,856,533,283.4	6,306.0	178,585,837.3	3,644,977,712.0	6,202.0	148,604,773.6

Тэмдэглэл:(0.0)-үйл ажиллагаа эрхлээгүй,(#N/A)-Фина системд тайлан ирүүлээгүй

Дүрслэл-24

Даатгалын хохирол үнэлгээний орлого /сая төгрөг/




6.ДААТГАЛЫН САЛБАРТ ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

Тус Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д заасны дагуу чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд даатгалын салбарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргаан, өргөдөл гомдол 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 38 ирснээс 32 өргөдөл гомдол хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэгдсэн бөгөөд 6 өргөдөл, гомдол хянагдаж байна. Дээрх өргөдөл гомдлыг даатгалын төрлүүдээр авч үзвэл Жолоочийн хариуцлагын албан журмын, Тээврийн хэрэгслийн, Орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн, Мэргэжлийн хариуцлагын, Мал

амьтны даатгал, мөн хохирол үнэлгээний тайлан, дүнг шалгуулах, тус Хорооноос батлагдсан дүрэм, журмыг хэрхэн ойлгох талаар Даатгалын компаниудаас ирүүлсэн хүсэлтүүдийг хуулийн дагуу урьдчилан шийдвэрлэж нийт 15,097,473.00 (арван таван сая ерэн долоон мянга дөрвөн зуун далан гурав) төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг төлүүлж ажилласан байна. 2017 оны 1 дүгээр улиралд ирсэн нийт өргөдөл, гомдлын харьцааг даатгалын компаниудаар харуулав.


Дүрслэл-25



2017 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын салбарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлбэрээр ангилан харуулбал Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 39 хувь буюу хамгийн өндөр байх бөгөөд Тээврийн хэрэгслийн даатгал 21 хувь, харин даатгалын бусад асуудлууд үлдсэн хувийг эзэлж байна.

Дүрслэл-26

Өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр



2017 оны 1 дүгээр улиралд даатгалын салбарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд хугацаанд нь урьдчилан шийдвэрлэж нийт 15,097,473.00 (арван таван сая ерэн долоон мянга дөрвөн зуун далан гурав) төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг төлүүлэн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалж ажилласан байна. Талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэж, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн хохирлыг барагдуулж нөхөн төлбөр төлүүлсэн дүнг даатгалын компани тус бүрээр доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт-19

№	Даатгалын компани	Даатгалын төрөл	Төлүүлсэн нөхөн төлбөрийн дүн
1	“Миг даатгал” ХХК	Орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн /ипотек/ даатгал	12,425,000.00
2	“Тэнгэр даатгал” ХХК	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	810,973.00
3	“Номин даатгал” ХХК	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	311,500.00
4	“Мандал даатгал” ХХК	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	1,550,000.00
Нийт дүн			15,097,473.00

7. ДҮГНЭЛТ

Монгол улсын даатгалын салбарын 2017 оны 1 дүгээр улирлын санхүү, даатгалын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгыг эмхэтгэж, салбарын гол үзүүлэлтүүдийг сүүлийн жилүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулж, дүгнэлээ.

2017 оны 1 дүгээр улиралд давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 224.7 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 80.5 хувийг ердийн даатгалын компаниуд, 3.4 хувийг урт хугацааны даатгалын компани, 16.1 хувийг давхар даатгалын компани эзэлж байна. Нийт хөрөнгийг өмнөх онтой харьцуулахад 19.0 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 8.4 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 19.4 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 7.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 37.5 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.3 тэрбум төгрөгөөр буюу 37.7 хувийн өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2017 оны 1 дүгээр улиралд нөхөн төлбөрт 8.8 тэрбум төгрөгийг олгож, салбарын хэмжээнд хохирлын харьцаа /цэвэр/ 42.7 хувьтай байна.

2017 оны 1 дүгээр улиралд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 20.0 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн нь нийт хураамжийн 53.4 хувьтай тэнцэж байна. Давхар даатгалын хураамжийн зардал өмнөх оны мөн үеийн дүнгээс 6.9 тэрбум төгрөгөөр буюу 52.8 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь дотоодын даатгагч компаниуд их хэмжээний эрсдэлээ гаднын компанид даатгаж валютын гарах урсгал ихэссэнийг харуулж байна.

Давхар даатгалын болон даатгалын компаниудын тайлант үеийн цэвэр ашиг 877.3 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 77.4 хувиар буурсан байна. Даатгагч нарын ашигт


ажиллагаанд гол нөлөөлөх харьцаануудыг тооцож үзвэл салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 7.3 хувь, үндсэн үйл ажиллагааны зардлын харьцаа 51.1 хувь, хохирлын харьцаа 23.1 хувь, зардал ба хохирлын хосолсон харьцаа 97.1 хувьтай байна.

Тайлант хугацаанд даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг авч үзвэл даатгалын нийт хураамжийн орлогын 11.0 орчим хувийг даатгалын төлөөлөгч, 12.0 орчим хувийг даатгалын зуучлагч төвлөрүүлсэн ба үүнээс 48.7 хувийг даатгалын зуучлагч банк төвлөрүүлсэн байна. Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд 6,202 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж, 148.6 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын нэвтрэлт, нягтрал нь олон улсын дундаж түвшнээс харьцангуй доогуур үзүүлэлттэй, мөн сүүлийн жилүүдэд тодорхой өсөлт ажиглагдахгүй байна. 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 12,023 /ойролцоогоор 5 ам доллар/ төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 35.0 хувиар өссөн байна. Харин даатгалын салбарын эдийн засаг, санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг үзүүлэх үзүүлэлт болох даатгалын нэвтрэлтийн түвшин тооцоход 0.66 хувь байгаа нь олон улсын дундаж үзүүлэлтээс харьцангуй доогуур байна. Жишээлбэл, олон улсын томоохон давхар даатгалын Swiss Re компанийн гаргасан судалгаанаас харахад 2015 онд хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын нэг хүнд ногдох нийт даатгалын хураамжийн орлого 135 ам.доллар, үүнээс ердийн даатгалд 64 ам.доллар, амьдралын даатгалд 71 ам.доллар ногдож байна. Мөн даатгалын нэвтрэлт нь хөгжиж буй эдийн засагтай улс орнуудад өсөх хандлагатай байгаа ба 2015 онд 2.9 хувийн үзүүлэлттэй байна.

Дүрслэл-27

Даатгалын нэвтрэлт, нягтрал



-ДААТГАЛЫН ГАЗАР-